

НАГ, Х-1, Д-1, ХН-121

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ХАРЬЯАТ АРДУУДЫГ ЦЭРГИЙН АЛБА ХААЛГАХ ТУХАЙ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Манай монголчууд гадаадын эзэрхэг харгисын талхигдлаас ангижирч эрх чөлөөгөө олж Бүгд Найрамдах Ардын эрхтэй засгийг байгуулж гадаадыг сэргийлж дотоодыг хөгжүүлэн боловсруулах явдалд бүгдээр чармайн зүтгэвээс зохих учир юуны урьд гадаадын харгис дайснаас ард түмэн улс төр, нутаг үндсээ батлан хамгаалах хүчирхэг баатар цэрэг байгуулан хүчнийг зузаатгахыг нэн чухал болговоос зохимуй.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Ард түмний хөрөнгө ба нутаг үндэс, улс төрийг гадаадын харгис дайснаас хамгаалах явдлыг гагцхүү дайчилсан зэвсэгт цэрэг ба нутгийн бэлтгэл цэрэг олон түмэн ардын хүчинд итгэх тул энэ нь нийт цэргийн хүмүүсийн үүрэх үүрэг сахих тангарагт журмын сахилга мөн хэмээн бишрэн итгэвээс зохимуй.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Ард түмний хөрөнгө ба улс төрийг гадаадын дайснаас хамгаалахуйд гагцхүү цэргийн хүчинд итгэх боловч цэргүүд нь зэвсэг ба уналга хүнс хувцасны зэрэг чухал хэрэглэх зүйлд итгэвээс зохих тул тэдгээр зүйлийг сайжруулан хэрэглэх тухайд гачигдал сааталгүй болгох явдлыг цэргийн дээд захиргааны газраас эрхлэн гүйцэтгэвээс зохимуй.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Бүх Монгол Улсын цэргүүд нь жинхэнэ цэрэг бэлтгэл цэрэг үйлдүүлэхээр дайчлах татан авсан цэрэг болох бөгөөд хоёр жилийн хугацаагаар халагдах болмуй. Бэлтгэл цэргүүд нь хоёрын хугацаа дуусч халагдаж буцсан ба нутагт бүхий дайчлан эргүүлэггүй цэргүүд болох тул цөм цэргийн сахилга журам тусгай заавар дүрэм тушаал зэргийг дагаж явахаас гадна үүнээс хойш идэр насны эрчүүдийг цэрэгт дайчлахуйд нас тогтоож дайчлан татваас зохимуй.

ТАВДУГААР ЗҮЙЛ. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын жинхэнэ цэргүүд нь арван найман наснаас дөчин таван нас хүртэлх харын данс бүхий хүмүүст цэргийн бүртгэл олгож жинхэнэ цэргийн албанаа хэрэглэхуйд бэлтгэвээс зохимуй. Тайлбарлах нь, энэхүү бүртгэл авсан цэргийн эрсээс дайчлан татан авах ба хөдөө нутагт сургууль үйлдүүлэхуйд үүнээс хойш цөм нас насаар түмлэн татан авч гүйцэтгэх тул эрхэм доорд баян үгээгүй хэмээн татаж түлхэх эгмийг нэгмөсөн устгаж нийгэм тэгшээр дагаж шийтгэвээс зохимуй.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Жил бүр жинхэнэ цэргийн албанд аль аль насны эрсийг дайчлан татан авч сэргийлүүлсэн буюу сургууль газраас үнэмлэх бичиг олгуулан халж орон нутагт буцааж биеийг амруулан газар орны хэрэгт туслалцуулж бэлтгэл цэрэг болгон гэр орны аж ахуйг үйлдүүлвээс зохимуй.

ДОЛДУГААР ЗҮЙЛ. Дайчлан татан авч сэргийлүүлсэн буюу сургууль үйлтгүүлсэн цэргүүдийн хоёр жилийн хугацаа гүйцмэгц тус тусын биеийг амруулан газар орны хэрэг туслалцуулж, бэлтгэл цэрэг болгон гэр орны аж ахуйг үйлтгүүлмээс зохимуй

НАЙМДУГААР ЗҮЙЛ. Нутагт бүхий бэлтгэл цэрэг ба цэргийн бүртгэл авсан идэр насны эрчүүдийг жил бүр хугацаа тогтоож нутгийн газруудад сургууль үйлдүүлэн боловсруулах явдлыг цэргийн явдлын яамнаас заавар гаргаж дагаж шийтгүүлвээс зохимуй.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Арван найман нас хүрээд бүртгэл аваагүй мөн арван найман наснаас дөчин таван нас хүртэлх цэргийн эрсээс дайчлан үйлдүүлэх эрхэд ногдох цэргийн хүмүүс хааяа зайлсхийн ов мэх гаргаж залилан зайлж явах ба мөн түүний залилан явахыг мэдсээр

агаад даран далдалсан гэм учир гарваас цэргээс оргосон ба оргодол цэргийг нуун дарсан дүрмийн ёсоор тус тус цээрлүүлэн шийтгэхээс гадна зохисгүй магад самуун хэрэг эдүүлэн явах зэргээр цэргийн сахилга журмыг гачигдуулваас тогтоосон дүрмийн ёсоор хүндээр цээрлүүлэн шийтгэх явдлыг мөн аймаг хошуудын цэргийн хэлтсээс дараалан сум баг арван гэрийн дарга нар хүртэл хянан дагаж шийтгүүлвээс зохимуй.

АРАВДУГААР ЗҮЙЛ. Арван найман наснаас дөчин таван нас хүртэлх цэргийн эрсийг жинхэнэ цэрэгт дайчлан татан авахуйд аж төрж чадахгүй эцэг эхийн ганц хөвгүүн бөгөөд өөр ажил хийж цадах хүн нэг ч үгүй болвоос дайчлан цэргийн албанаас чөлөө олгож бэлтгэл цэрэгт хүлээлгэж болмуй. Хэрэв ажил хийж чадах өөр хүн нэг буй болж шалтгаалах буюу арван гэр сум багийн дарга нар нуурчлан өнгөрүүлсэн зэрэг гэм учир гарваас цэргийн дүрмийн ёсоор хүнд цээрлүүлэн шийтгэвээс зохимуй.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Одоо эцэг эхийн хөвгүүн хоёр гурав хэд боловч жинхэнэ цэргийн бүртгэл авсан данстай дайчлах насанд тохирох хүмүүс болвоос нэгэнт чөлөө олгож бэлдсэн цэрэгт оруулан хүлээлгэж эцэг эхийг асран сувилуулж гэр малыг тэнхрүүлэн аж ахуйг гүйцэтгүүлж бусдыг цөм дайчлан татваас зохимуй.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Аливаа цэргийн албанаа томилогдсон хүмүүсийг хошууны эмчийн комиссоор үзүүлж биед үнэхээрийн итгэхгүй сохор тахир дутуу халцах зэргийн хүнд өвчтэй нь үнэн аваас цэргийн албанаас чөлөө олгож үнэмлэх бичиг олговоос зохимуй.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Хоёр жилийн хугацаагаар дайчлаж ирүүлсэн цэргүүдээс бие өвдөж эмчийн комиссоор үзүүлэн албанаа тэнцэхгүй болж бүрмөсөн буюу түр чөлөөгөөр халагдах нь болвоос өөр өөрийн хороо ангиас үнэмлэх бичиг олгуулж буцааваас зохимуй.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Байлдаан бүхий цагт бэлтгэл цэргийг тэр тухай тусгай заавар дүрмийн ёсоор дайчлан татваас зохимуй.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ. Эмчийн комиссоор батлагдсан бие өвчтэй буюу дөчин таван наснаас хэтэрсэн ба арван найман насанд хүрээгүй хүмүүсийг цөмлөн байлдааны цагт аж хийж чадахгүй хүмүүст тоолвоос зохимуй.

АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Жинхэнэ цэргийн хүмүүс дөчин таван нас өнгөрсөн буюу эмчийн комиссоор үзүүлэн бүрмөсөн чөлөө олгосон бие өвчтэй хүмүүс лам хар амины ёсоор явахыг өөр өөрийн дураар болгохоос бус цэргийн хувьд халбадан хэлэлцэх явдалгүй болговоос зохимуй.

АРВАН ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Эцэг эхийн бага хөвгүүнийг үүнээс урагш

- Нэг болвоос даруй цэргийн эр болгохуйд бэлтгэвээс зохимуй.
- Хоёр болвоос нэгийг эцэг эхийг сувилахуйд бэлтгэн үйлдмүй. Хэрэв хоёроос илүү гурав дөрөв хэд боловч эцэг эхээс хуваарилан дуртай лам болсугай хэмээх аваас арван гэр сум багийн дарга нар аль нэгийг лам болгож алинаар эцэг эхийг сувилуулах саналыг авч хошууны цэргийн хэлтэсд мэдүүлж дансанд тэмдэглүүлэн лам болговоос зохимуй.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ. Жинхэнэ цэргийн албанаа зүтгэсүгэй хэмээх дотоод гадаадын хүмүүсийг авч болох боловч гагцхүү цэргийн яамнаас тэдний уг санал зорилт юу болох ба авч болох эсэх зэргийг урьдаар нарийвчлан хянан мэдэж тухайг үзэж гүйцэтгэн шийтгэвээс зохимуй.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Жинхэнэ цэргийн эрсийг дайчлан татан авах ба нутгийн сургууль үйлдүүлэх зэргэд цөм дүрмийн ёсоор явуулах явдлыг аймаг хошуудын цэргийн хэлтсүүдээс хэзээ ямагт хичээн оролдож гүйцэтгэсээр байваас зохимуй.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ. Дайчлах цэрэгт урьд гажуу самуун явдал санал ховдог шунахай зэргийн хэрэг эдүүлж ял шийтгүүлсэн буюу язгуур угсааны холбоогоор албаны газраас сонгох эрхгүй болгосон хүмүүсийг татан авч болох боловч жагсаалын бус албан ба эсвээс цэргийн ард буй ажлын зэрэг албан хаалгаваас зохимуй.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Аливаа техникийн зэрэг чухал сургууль үйлдэх цэргүүдийн хугацааг цөм тусгай тогтоосон дүрмийн ёсоор дагаж явуулваас зохимуй.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Аливаа цэргийн дээд тушаалын дарга нар ба комиссар бичиг ажлын тушаалтанд хоёр жилийн хугацааг баримт болгох явдалгүй цөм тухайг үзэж цэргийн дээд захиргааны газраас тогтоон шийтгэмүй.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Хүрээ сүм хийд орон хурлын газар үргэлжид сууж бүхий данстай лам нарыг цэргийн албан томилон авч үл болохоос гадна мөн тэдний лам нараас орон хийд сүм хурал ба ламын ёс журмыг өргөж жинхэнэ хар хүний адил явдалтай болсон нь байх аваас нутгийн эрх баригчид харын данснаа оруулан авч нас тэнцэх нь бүртгэл олгуулваас зохимуй. Үүнд тайлбарлах нь, лам хүмүүсийг харын ёсоор явах нь буй аваас уг шалтгаан учир санал зорилго үйлдсэн явсан явдлын үнэн магадыг хошууны цэргийн хэлтсээс сайтар хянаж шийтгэвээс зохимуй

Монгол улсын арван тавдугаар он арван сарын арван зургаан.